



МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧ
Б.ЛХАГВАСҮРЭН ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛТ

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: statgreatkhural@parliament.mn
http://www.parliament.mn

2024.11.06 № 29

Зээлийн хүүг бууруулах стратегийн
хэрэгжилтийн талаар

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 21 дүгээр тогтоолоор "Зээлийн хүүг бууруулах стратеги"-ийг баталж, тогтоолын 2 дугаар заалтад "... зээлийн хүүг 2019 оны суурь түвшнээс 4 нэгж хувиар бууруулж, 2023 оны эцэст сарын 1 хувьд хүргэх..." яаралтай арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газар, Монгол банк, Санхүүгийн зохицуулах хороонд тус тус даалгасан байна.

Статистикийн мэдээллийн нэгдсэн сангийн зээлийн хүүний мэдээллээс харахад тогтоол батлагдахаас өмнөх үеийн буюу 2019 оны 12 дугаар сарын зээлийн хүү 16.9 хувь байсан байх бөгөөд тогтоолыг хэрэгжүүлж эхэлснээс хойш 3 жилийн хугацаанд буюу 2023 оны 12 дугаар сарын байдлаар 16.7 болсон байгаа нь зээлийн хүүг бууруулах стратегийн хэрэгжилт хангалтгүй байгааг илтгэж байна.

Иймд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, 37 дугаар зүйлийн 37.1.1 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийг тус тус үндэслэн, бүрэн эрхийнхээ хүрээнд зээлийн хүүг бууруулах стратегийн зарим арга хэмжээний хэрэгжилттэй холбоотой дараах асуултыг Танд тавьж байна. Үүнд:

- Стратегийн 2.1 дүгээр арга хэмжээний 2.1.1, 2.1.2 дугаар дэд арга хэмжээ;
- Стратегийн 2.4 дүгээр арга хэмжээний 2.4.1 дүгээр дэд арга хэмжээ;
- Стратегийн 2.5 дугаар арга хэмжээний 2.5.1, 2.5.2, 2.5.3 дугаар дэд арга хэмжээний хэрэгжилт, үр дүнг дэд арга хэмжээ бүрээр гаргаж ирүүлнэ үү.

Энэхүү асуултын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэгт заасан хугацаанд ирүүлэхийг Танаас хүсье.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН

О.НОМИНЧИМЭГ

